



Оюу Толгой ХХК-ийн 2013 оны шилдэг ажилтан Д.Жавхлант:

“ОЮУ ТОЛГОЙ БОЛ ТӨСӨЛ БИШ ҮЙЛДВЭРЛЭЛ ЖИГДЭРСЭН УУРХАЙ”

Та Жактай танилц. Түүний хувьд 2004 оноос Оюу Толгойн бүтээн байгуулалтад оролцож, одоо үйл ажиллагаа нь жигдэрсэн уурхайд шижигнэсэн залуустай мөр зэрэгцэн зэс эрдэнийн баяжмал үйлдвэрлэх ажилд хувь нэмрээ оруулж байгаа тэргүүний ажилчин.

Хамгийн өндөр зэрэглэл буюу 6-р зэргийн мастер кранчин. Өдгөө 34 дэх жилдээ дэлхийн таталцлын хүчийг техникийн аргаар сааруулж, олон мянган тонн ачааг өргөж, буулгаж, явна. Бусад

мэргэжлийн адилаар түүний ажил алдах эрхгүй, өндөр хариуцлага шаарддаг.

Оюу Толгойчууд түүнийг “Жак” ах хэмээн хүндлэн дууддаг юм. Тэрээр “Барилга, бүтээн байгуулалтаас үйлдвэрлэлд шилжсэн энэ чухал үед шинэ үеийнхэндээ мэдлэг, туршлагаасаа хуваалцаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд сахиж, хөдөлмөрийн үр ашгийг дээшлүүлэн компанийнхаа хамт олны итгэлийг өндөрт өргөж явах болно” гэлээ